



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 1/62

Улаанбаатар хот

Г Дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай Г

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, Монголын Үндэсний музейн 2024 оны дотоод хяналт шалгалт зохион байгуулах төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын “Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдалд дотоод хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийг хавсралт /1/-р, “Дотоод хяналтын төлөвлөгөө”-г хавсралт /2/-р, “Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг үнэлэх санал асуулгын хуудас”-ыг хавсралт /3/-р, “Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах ажлын хүрээнд хийх ганцаарчилсан ярилцлагын хуудас”-ыг хавсралт /4/-р тус тус баталсугай.

2. Дотоод хяналт шалгалт зохион байгуулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Дотоод хяналт шалгалтын баг /Т.Зөнбилэг, Э.Оюунтуяа, Н.Эрдэнэтуяа/
- Удирдлагын төлөөлөл Д.Мөнхтогоо /МСМАЗТ-ийн дарга/
- Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан Ч.Баяндэлгэр
- Систем хөгжүүлэлт, аюулгүй байдлын инженер Э.Энх-Амгалан
- Ажиллагсдын төлөөлөл И.Мөнхчимэг /Боловсролын ажилтан/

3. Дотоод хяналт шалгалттай холбоотой төсөв шийдвэрлэхийг Ерөнхий нягтлан бодогч /Д.Батцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Дотоод хяналт шалгалтын үр дүнг тайлагнаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт шалгалтын баг /Т.Зөнбилэг, Э.Оюунтуяа, Н.Эрдэнэтуяа/-т үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТХР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭНХБАТ



1424186

Монголын Үндэсний музейн захирлын
2024 оны 25 дугаар сарын 29 өдрийн
Тоот тушаалын 1 дүгээр Хавсралт



ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙ, АЮУЛГҮЙ БАЙДАЛД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

Удиртгал

Байгууллагын дотоод хяналт шалгалтын 2024 оны ажлын төлөвлөгөөнд туссаны дагуу ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, нөхцөл, аюулгүй байдалд энэхүү удирдамжийн хүрээнд дотоод хяналт шалгалт хийнэ. Энэ чиглэлээр хяналт шалгалт хийсэн дүнг ашиглан байгууллагын удирдлага болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, ажилтны зүгээс нэн тэргүүнд ямар арга хэмжээ авч, цаашид юу шийдвэрлэх шаардлагатай байгааг тогтоож, зохих арга хэмжээг авах юм.

Хяналт шалгалтын ажлын зорилго:

Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдлыг тогтоож, цаашид шийдвэрлэх арга замыг тодорхойлох

Хяналт шалгалтын зорилт:

- ✓ Удирдлагын төлөөлөл, Ажилтан, Систем хөгжүүлэлт аюулгүй байдлын инженер, дотоод хяналтын баг ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ өгөх,
- ✓ Өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын чиглэлээр хийж буй үйл ажиллагааны давуу, сул талыг илрүүлж, хэрэгцээг тодорхойлох,
- ✓ Нөөц бололцоог ашиглан осол, аваараас урьдчилан сэргийлж, аюулгүй байдлыг хангахын тулд хэн, ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг тогтоож сайжруулах арга замыг тодорхойлох,

Хяналт шалгалт хийх багийн бүрэлдэхүүн:

- ✓ Удирдлагын төлөөлөл Д.Мөнхтоогоо /МСМАЗТ-ийн дарга/
- ✓ Дотоод хяналт шалгалтын баг /Т.Зөнбилэг, Э.Оюунтуяа, Н.Эрдэнэтуяа/
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан Ч.Баяндэлгэр
- ✓ Систем хөгжүүлэлт аюулгүй байдлын инженер Э.Энх-Амгалан
- ✓ Ажиллагсдын төлөөлөл И.Мөнхчимэг /Боловсролын ажилтан/

Хяналт шалгалт хийх газар (хаанаас):

✓ Монголын Үндэсний музейн БТУХэлтэс, МСМАЗТөв, ЭШТөв, Сан хөмрөгийн алба, Аюулгүй байдал үйлчилгээний алба, БОНХМАлба

Түүвэр (хэнээс мэдээлэл авах):

- ✓ Ажилтнуудаас системчилсэн түүврийн аргыг ашиглан үнэлгээнд оролцуулахаар түүвэрлэн сонгоно. Түүвэрт хамрагдах ажилтан, ажилчдын жендерийг харгалзан сонгоно.
- ✓ Үнэлгээнд сонгогдсон ажилтнуудыг хамруулна.

Албан тушаал	Арга хэрэгсэлэл	
	Асуулга	Ганцаарчилсан ярилцлага
Төв, албаны дарга	2	
Ерөнхий нягтлан бодогч	1	
Эрдэм шинжилгээний ажилтан	3	
Арга зүйч	2	1
Сан хөмрөгч	2	1
БМС	1	
Боловсролын ажилтан	1	
Номын санч	1	
Тайлбарлагч	1	1
Цахилгаанчин	1	
Харуул	2	1
Сантехникч	1	
Үзмэр харгалзагчид	2	2
Үйлчлэгч		2
Нийт	20	8

Мэдээлэл өгөх хүмүүстэй хэрхэн холбогдох:

Дотоод хяналт шалгалт хийх ажлын хэсгийн гишүүд үнэлгээнд хамрагдах ажилтнуудтай ямар нэг хүнээр дамжуулахгүйгээр биечлэн уулзаж мэдээлэл цуглуулна.

Мэдээлэл цуглуулах арга хэрэгслүүд:

- а. Баримт бичгийн шинжилгээ
- б. Санал асуулга
- в. Ганцаарчилсан ярилцлага

Мэдээлэлд анализ хийх урьдчилсан төлөвлөгөө: Тоон болон чанарын мэдээлэлд боловсруулалт хийх арга

Хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө

	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	Удирдамж, ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулах	2 хоног	Дотоод хяналт шинжилгээний баг
2	Мэдээлэл цуглуулах арга хэрэгслүүдийг боловсруулах	2 хоног	
3	Санал асуулгыг хувиалан олшруулах	1 хоног	
4	Ажилтнуудаас мэдээлэл цуглуулах	2 хоног	
5	Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, боловсруулалт хийх	4 хоног	
6	Хяналт шалгалтын тайлан боловсруулах	4 хоног	
7	Тайланг захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, шийдвэр гаргах	1 хоног	




Хяналт шалгалтад зарцуулах төсөв

№	Гүйцэтгэх ажил	Зардлын тооцоо	Гарах зардал
1	Асуулга болоод ярилцлагын аргачлалыг хувиалан олшруулах цаас	2 боодол	20000
2	Принтерийн хор	1	60000
3	Каноны хор	1	10000
Нийт төсөв			90000

Дотоод хяналт шалгалтын үр дүнг хэлэлцүүлж шийдвэр гаргах хугацаа

- ✓ Ажлын хэсэг дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж 2024 оны 6-р сарын 07-ны дотор хэлэлцүүлж шийдвэр гаргуулна.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН: ДОТООД ХЯНАЛТЫН БАГ

 /Г.ЗӨНБИЛЭГ/
 /Н.ЭРДЭНЭТУЯА/
 /Э.ОЮУНТУЯА/

Монголын Үндэсний музейн захирлын
2024 оны 25 дугаар сарын 19 өдрийн
ТООТ тушаалын 1 дугаар Хавсралт



ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1.	Удирдамж, ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулах	2024.05.28-05.29	Дотоод хяналт шинжилгээний баг
2.	Мэдээлэл цуглуулах арга хэрэгслүүдийг боловсруулах	2024.05.28-29	
3.	Санал асуулгыг хувиан олшруулах	2024. 05.30	
4.	Ажилтнуудаас мэдээлэл цуглуулах	2024. 06.03-04	Дотоод хяналт шинжилгээний баг, ажлын хэсэг
5.	Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, боловсруулалт хийх	2024. 06.03-06	
6.	Хяналт шалгалтын тайлан боловсруулах		
7.	Тайланг захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, шийдвэр гаргах	2024. 06.07	

Төлөвлөгөө боловсруулсан:  /Т.Зэнбилэг/

 /Н.Эрдэнэтуяа/

 /Э.Оюунтуяа/

Монголын Үндэсний музейн захирлын
2024 оны 12 дугаар сарын 19 өдрийн
...тоот тушаалын 3 дугаар Хавсралт
VXAL025

Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг үнэлэх санал асуулгын хуудас
(Ажилтнуудад зориулав)

.....онысарын өдөр

Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдалд дотоод хяналт шалгалт хийж, цаашид сайжруулах арга замыг тодорхойлох ажлын хүрээнд авч буй санал асуулгад оролцохыг урьж байна. Та бүхний хариултуудыг үндэслэн хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын үйл ажиллагааг сайжруулах зорилготой юм.

Та бүхний өгсөн хариултуудын нууцыг бид чандлан хадгалах болно. Түүнчлэн та бүхнээс нэр усгүй мэдээллийг хүлээж авна.

Та бүхэн өөрсдийн санал бодлоо чөлөөтэй, үнэн зөв илэрхийлж, мөн нээлттэй асуултуудад аль болох тодорхой хариулах зэрэг нь бидний ажилд чухал ач холбогдолтой юм. Бид та бүхэнд судалгааныхаа үр дүнг танилцуулж байх бөгөөд нэгдсэн тайлангаа 6-р 12-ны дотор хүргэнэ.

Хамтран ажилласан та бүхэнд баярлалаа!

Оролцогчдын талаарх мэдээлэл

1. Би ... /холбогдох дугаарыг дугуйлна уу/

- 1) Төв, албаны дарга
- 2) Ерөнхий нягтлан бодогч
- 3) Эрдэм шинжилгээний ажилтан
- 4) Арга зүйч
- 5) Сан хөмрөгч
- 6) БМС
- 7) Боловсролын ажилтан
- 8) Номын санч
- 9) Тайлбарлагч
- 10) Цахилгаанчин
- 11) Харуул
- 12) Сантехникч
- 13) Үзмэр харгалзагчид
- 14) Үйлчлэгч

2. Та аль албанд ажилладаг вэ?

- 1) Аюулгүй байдал үйлчилгээний алба
- 2) Сан хөмрөгийн алба
- 3) БОНХМАлба
- 4) ЭШТ
- 5) МСМАЗТ
- 6) БТУХ

3. Таны хүйс

- 1) эрэгтэй
- 2) эмэгтэй

4. Таны ажлын байрны нөхцөл?

- 1) Хэт халуун
- 2) Хэт хүйтэн
- 3) Тоосжилттой
- 4) Химийн бодистой харьцдаг
- 5) Нэг хөдөлгөөн давтагдан хийдэг ажлын байр
- 6) Энгийн
- 7) Бусад /нөхөж бичих/

5. Та хэдэн жил энэ ажлын байранд ажиллаж байна вэ?

- 1) 1-2 жил
- 2) 3-5 жил
- 3) 6-10 жил
- 4) 10-15 жил
- 5) 15-20 жил
- 6) 20-иос дээш жил

Баримт мэдээлэл

6. Та өдөрт хэдэн цаг ажилладаг вэ? Бичнэ үү

7. Та тус ажлын байранд ажиллах явцад дараах асуудал үүсч байсан уу?

- 1) Осолд орсон
- 2) Хүнд гэмтсэн
- 3) Хөнгөн гэмтсэн
- 4) Мэргэжлээс шалтгаалах өвчин туссан
- 5) Химийн бодисын хурц хордлого туссан
- 6) Аль аль нь үгүй
- 7) бусад.....

8. Осол, аваар, мэргэжлээс шалтгаалах өвчин гарч буй нийтлэг шалтгаан юу вэ?

- 1) Ажилтны өөрийн хариуцлагагүйгээс
- 2) Анхааруулах санамж, тэмдэг, тэмдэглэгээгүйгээс
- 3) Ажилтнаас аюулыг мэдээлэх хуудсаар мэдээлэл авдаггүйгээс
- 4) Тоног төхөөрөмжид хамгаалалт хийгээгүйгээс
- 5) Ажлын байрны эрсдэлийг бууруулах арга хэмжээ аваагүйгээс тухайлбал, тоос, шуугиан, доргион, химийн бодисын ууршилт гэх мэт
- 6) Бусад

9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтанд сүүлийн 1 жилд хэдэн удаа хамрагдсан бэ?

- 1) 8-10 удаа
- 2) 5-7 удаа
- 3) 3-4 удаа
- 4) 1-2 удаа
- 5) Огт хамрагдаагүй

- 10 Танай байгууллагын эрсдэл өндөртэй ажлын байранд ажилладаг ажилтнууд ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг тогтмол өмсөж хэвшсэн үү?
- 1) тогтмол
 - 2) заримдаа хэрэглэдэггүй
 - 3) огт хэрэглэдэггүй бол шалтгаан нь юу вэ?
-
-

Үнэлгээ

Заавар: Та асуултад хариулахдаа "огт шаардлага хангаагүй/ маш муу гэвэл 1 дугаарыг", "шаардлагад нийцээгүй/хангалтгүй гэвэл 2 дугаарыг", "дунд зэрэг гэвэл 3 дугаарыг", "шаардлагад нийцсэн/сайн гэвэл 4", маш сайн шаардлагад нийцсэн/маш сайн гэвэл 5", "мэдэхгүй бол 0 дугаарыг" сонгож дугуйлна уу.

огт шаардлага хангаагүй/ маш муу	шаардлагад нийцээгүй/ хангалтгүй	дунд зэрэг	шаардлагад нийцсэн/ сайн	маш сайн шаардлагад нийцсэн/ маш сайн	Мэдэхгүй бол
1	2	3	4	5	0

- 11 Та аюулгүй ажиллагааны зааврыг хэр мөрдөж ажилладаг вэ?
- 1 2 3 4 5 0
- 12 Бусад ажилтнууд аюулгүй ажиллагааны зааврыг хэр мөрдөж ажилладаг вэ?
- 1 2 3 4 5 0
- 13 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр зохион байгуулдаг сургалтын чанарыг үнэлнэ үү.
- 1 2 3 4 5 0
- 14 Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн чанар, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байдлыг үнэлнэ үү.
- 1 2 3 4 5 0
- 15 Ажилтны аюулгүй байдлыг хамгаалж тоног төхөөрөмжид хамгаалалтыг бүрэн хийсэн үү?
- 1 2 3 4 5 0
- 16 Ажлын байрны тоосыг бууруулах арга хэмжээний чанарыг үнэлнэ үү?
- 1 2 3 4 5 0
- 17 Таны бодлоор ажилтны хөдөлмөрлөх аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлсэн гурван гол ололттой үйл ажиллагаа юу вэ?
- 1) _____
- 2) _____
- 3) _____

- 18 Танай байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйлчилгээг та бусад газартай харьцуулбал хэрхэн үнэлэх вэ? Тохирох үнэлгээг сонгож дугуйлна уу.

маш сайн дунджаас дээш дундаж дунджаас доогуур огт хангалтгүй

Санал

- 19 Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүйн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж үзэж буй хэсгийг олж тэмдэглэнэ үү? Эдгээрээс нэн тэргүүнд сайжруулах шаардлагатай гэж үзсэн гурван хэсгийн урд 1, 2, 3 гэж дугаарлан бичнэ үү.

- Ажилтнууд аюулгүй ажиллагааны зааврыг дагаж мөрддөг соёлтой болох
 - Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах
 - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр зохион байгуулж буй сургалтын чанарыг нэмэгдүүлэх
 - Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн чанар, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх
 - Ажилтны аюулгүй байдлыг хамгаалж тоног төхөөрөмжид хамгаалалтыг бүрэн хийх
 - Ажлын байрны тоосыг бууруулах арга хэмжээний чанарыг сайжруулах
 - Ажлын байрны доргион, шуугианыг бууруулах арга хэмжээний чанарыг сайжруулах
 - Ажлын байрны агаарт химийн бодисын ууршилтын хэмжээг бууруулах арга хэмжээний чанарыг сайжруулах
 - Ажилчдаас санал гомдол гарсан нөхцөлд түргэн шуурхай шийдвэрлэж өгдөг болох
 - Бусад. Тодруулан бичнэ үү.
-

20 Ажлын байрны нөхцөл, аюулгүй ажиллагааг хэрхэн сайжруулж болох талаар өөрийн саналаа бичнэ үү.

21 Ажлын байрны эрүүл ахуйг хэрхэн сайжруулж болох талаар өөрийн саналаа бичнэ үү.

22 Бидэнтэй хуваалцах өөр санал хүсэлт байвал бичнэ үү.

Хамтран ажилласан танд маш их баярлалаа!



Монголын Үндэсний музейн захирлын
2024 оны 05 дугаар сарын 19 өдрийн
1114 тоот тушаалын 4 дугаар Хавсралт

**“Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах ажлын
хүрээнд хийх ганцаарчилсан ярилцлагын хуудас
(Ажилтнуудад зориулав)**

.....онысарын өдөр

Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах дотоод хяналт шалгалт хийж, цаашид сайжруулах арга замыг тодорхойлох ажлын хүрээнд авч буй судалгаанд оролцохыг урьж байна. Та бүхний саналд үндэслэн ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах зорилготой юм.

Та бүхний өгсөн хариултуудын нууцыг бид чандлан хадгалах болно. Та бүхэн өөрсдийн санал бодлоо чөлөөтэй, үнэн зөв илэрхийлж, мөн нээлттэй асуултуудад аль болох тодорхой хариулах зэрэг нь бидний ажилд чухал ач холбогдолтой юм. Бид та бүхэнд судалгааныхаа үр дүнг танилцуулна.

Оролцогчдын талаарх мэдээлэл

1. Би ... /холбогдох дугаарыг дугуйлна уу/
 2. Систем хөгжүүлэлт, аюулгүй байдлын инженер
 3. Үзмэр харгалзагч
 4. Сантехникч
 5. Цахилгаанчин
 6. Харуул хамгаалалтын ажилтан
 7. Үйчлэгч
2. Хүйс
 - 1) эрэгтэй
 - 2) эмэгтэй
3. Ажлын нөхцөл.....

Баримт мэдээлэл

4. Ажлын байрныхаа хөдөлмөрийн эрүүл ахуйн үйл ажиллагааг хэр үнэлдэг бэ?
.....
.....
.....

5. Таны бодлоор ажилтны хөдөлмөрлөх нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлсэн ололттой үйл ажиллагаа юу вэ?

.....
.....
.....

6. Таны бодлоор ажилтны хөдөлмөрлөх эрүүл ахуйн орчин, аюулгүй ажиллагааны чиглэлээр дутагдалтай тал юу вэ?

.....
.....
.....

7. Энэ чиглэлээр юуг хэрхэн сайжруулах саналтай байна вэ?

.....
.....
.....

Бидний ажилд дэмжлэг үзүүлж, санал бодлоо илэрхийлсэн танд их баярлалаа.